

**ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭД ЭЭЛТЭЙ, ЭРСДЭЛГҮЙ ОРЧИНД МЭРГЭШСЭН ХАМТ ОЛОН, ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦСЭН ОНОШИЛГОО ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛНЭ.							
НЭГ. ОСОЛ ГЭМТЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТҮҮНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ БУУРУУЛАХ							
1.1	Осол гэмтлийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагуудаас осол гэмтлийн цахим мэдээллийн санг хүлээн авч, тайлагнана.		Үндэсний хэмжээний осол гэмтлийн өвчлөлийн цахим сан	2020.01.01-12.31 хүртэлх хугацаанд улсын хэмжээнд 145497 осол гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдсэн ба тухайн хугацаанд 58 эмнэлгээс сар бүр мэдээ аван ажилладаг.	2021 онд сар бүр осол гэмтлийн тусламж үзүүлдэг бүх шатны эрүүл мэндийн байгууллага ас осол гэмтлийн шинэ тохиолдлын мэдээг хүлээн авч, цахим сан бүрдүүлсэн байна.	- Эрүүл мэндийн сайдын 2014 оны 430 тоот тушаал, ГССҮТөвийн ерөнхий захирлын 2015 оны 07 тоот тушаалаар тус төвд осол гэмтлийн тандалтын нэгж байгуулагдаж, 2015 оноос осол гэмтлийн өвчлөл, нас баралтын сарын мэдээ, үйлчлүүлэгчийн мэдээллийг Эрүүл мэндийн сайдын 2011 оны 434, 2019 оны 611 тоот тушаалаар батлагдсан “Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас АМ-33” маягтын дагуу хүлээн авч ажилладаг. 2021 оны эхний 11 сарын байдлаар сар бүр осол гэмтлийн тусламж үйлчилгээ үзүүлэгч аймаг, нийслэлийн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн 58 байгууллагаас 116590 осол гэмтлийн шинэ	100%

						тохиолдлын сарын мэдээ болон цахим мэдээний санг хүлээн авч, нэгтгэн дүн шинжилгээ хийсэн. ГССҮТөв нь Статистик тандалт судалгааны албаны тархвар зүйн дүн шинжилгээ хийсэн нотолгоонд суурилсан мэдээллийг ашиглан Эрүүл мэндийн салбарын болон бусад салбарын байгууллагуудтай хамтран осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх үйл ажиллагаа зохион байгуулдаг.	
1.2	Осол, гэмтлийн шалтгааны дунд хамгийн их хувийг эзэлж байгаа унаж бэртэх болон бусад төрлийн осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, аюулгүй нөхцлийг бүрдүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах уулзалтууд зохион байгуулна.		Уулзалтаас гаргасан зөвлөмж	“Осол, гэмтлээс сэргийлэх тогтвортой хөгжлийн зорилт 2030” шийдвэр гаргагчдын улсын анхдугаар зөвлөгөөн болон үндэсний чуулган зохион байгуулсан.	Зөвлөмжийг холбогдох шатны байгууллагуудад хүргэсэн байна.	- Эрүүл Мэндийн Сайдын 2021 оны 9 сарын 15-ны өдрийн А/577 дугаар тушаалын дагуу “Ахуйн орчин дахь осол гэмтэлд өртөж болзошгүй эрсдлийг үнэлэх, заавар боловсруулж, хэрэгжүүлэх” төслийн хүрээнд Гэмтэл согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А-147 тоот тушаалыг хэрэгжүүлэх удирдамж, төлөвлөгөөг боловсруулан батлуулж төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. ✓ Ахуйн орчин дахь осол гэмтэлд өртөж болзошгүй эрсдлийг үнэлэх төсөл боловсруулж, санхүүжилт хүсэх, санхүүжилтийн дагуу материал бүрдүүлсэн.	100%

						✓ Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж батлуулсан ✓ Ахуйн орчин дахь осол гэмтэлд өртөж болзошгүй эрсдлийг үнэлэх төсөл боловсруулах зааврын талаар Олон улсын болон ДЭМБ-ын зөвлөмжийг судалж, орчуулсан ✓ Ахуйн орчин дахь осол гэмтэлд өртөх эрсдэлийг үнэлэх заавар, хяналтын хуудас боловсруулах ажлын хэсгийн уулзалт зохион байгуулж ажиллсан. ✓ Туршилтийн төслийг БГД 9-р хороон дээр хэрэгжүүлэж хийсэн. /БГД 9-р хорооны гэр хорооллын 20 айл, орон сууц, байшин хорооллын 20 айлуудаар бөглүүлж үр дүнг нэгтгэн дүгнэж, хэрэгжүүлэх явцад гарч тулгамдсан асуудлыг дахин хэлэлцэж, үнэлгээний зааварт тусгаж өгч ажилласан./ ✓ Санал хэлэлцэх ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулсан. ✓ Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн Ерөнхий захиралын 2021 оны 11 сарын 29-ны өдрийн А/147-р тушаалын дагуу ГССҮТ дээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлан, ажлын хэсгийн уулзалтыг зохион байгууллаж ажилласан.	
--	--	--	--	--	--	---	--

						✓ 8. Заавар ашиглах талаар мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан. /“Ахуйн орчин дахь осол гэмтэлд өртөж болзошгүй эрсдлийг үнэлэх, заавар боловсруулж, хэрэгжүүлэх” төслийн талаарх мэдээлэл, ахуйн орчин дахь осол гэмтэлд өртөх эрсдэлийг үнэлэх заавар, хяналтын хуудсыг хэрхэн ашиглах талаар Нийслэлийн 9 дүүргийн хэсгийн ахлагч болон хорооны нийгмийн ажилтан, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтануудыг хамруулан нийт 200 мэргэжилтэнд цахим сургалтыг зохион байгуулж ажилласан./	
1.3	Осол гэмтлээс сэргийлэх 14 хоногийн аян зохион байгуулах	Дотоод нөөц боломж	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	МУ-ын 3Г-ын 224-р тогтоолын дагуу жил бүрийн 01 сарын 15-ны өдрөөс 01 сарын 30-ны өдрийн хооронд тус аяныг зохион байгуулж хэвшсэн.	Аяны хүрээнд төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. Унаж гэмтэхээс сэргийлэх, түүний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах талаар иргэдийн мэдлэг	• ГССҮТ-ийн ерөнхий захирлын 2021 оны 01-р сарын 08 ны өдрийн А/06 тоот тушаалын дагуу “Хором бүрээ анхааръя-2, Унаж гэмтэхээс” сэргийлье” аянг зохион байгуулж удирдамж, төлөвлөгөөг боловсруулан батлуулж төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. • Унах, хальтирч тээглэх, бүдэрч унах, ахуйн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, осол гэмтлээс өөрийгөө хамгаалах талаар чадварт суралцах талаар зөвлөмж гаргаж иргэдэд мэдлэг ойлголт өгсөн. (Хэвтэн эмчлүүлэгчийн өрөө,	100%

					ойлголтыг дээшлүүлж, иргэд, хамт олон, аж ахуй нэгж байгууллагын хамтын ажиллагааг сайжруулсан байна.	тасалгаа, тасгийн мэдээллийн самбарт байршуулсан) • Унаж гэмтэхээс сэргийлэх чиглэлээр дараах зөвлөмж постерийг боловсруулан гаргасан. ✓ “Унаж бэртэхээс сэргийлье” ✓ “Хальтирч унахаас болгоомжил” ✓ “Унаж, бэртэж гэмтэхээс сэргийлье” ✓ “Уналтаас сэргийлж эрсдэлгүй орчин бүрдүүлье” ✓ “Гудамж талбайн уналтаас сэргийлье” ✓ “Барилгаас унахаас сэргийлье” ✓ 0-4 настай хүүхдийн уналт” ✓ Цана, чарганаас унаж гэмтэхээс сэргийлье” ✓ “Бага насны хүүхэд цонх, тагтан дээрээс унахаас сэргийлье” ✓ “Цана чарганаас үүдэлтэй осол гэмтлээс сэргийлье” г.м постерийг ЭМЯ, НЭМҮТ, ГССҮТ-ийн НЭМАлба, Нийслэлийн 9 дүүрэг, орон нутгийн 21 аймгийн засаг даргын тамгын газар, эрүүл мэндийн газар, төв хэлтэс, аж ахуйн нэгж байгууллагуудын цахим хуудас, web site-аар болон бусад олон нийтийн газрын цахим хуудсанд байршуулсан. • Орон нутгийн засаг даргын тамгийн газар, эрүүл мэндийн газар, төвүүд, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог мөн хангаж ажилласан. Орхон, Говь-	
--	--	--	--	--	--	---	--

						алтай, Завхан, Дорноговь, Баянхонгор, Дархан-уул, Дорнод, Увс, Төв аймагт тус аяныг өрнүүлж сургалт сурталчилгааг тогтмол явуулах, унаж гэмтэхээс сэргийлж зам талбайг цэвэрлэх, наалт санамжийг байршуулах, иргэд олон нийтэд цахимаар мэдээлэл өгөх, телевизээр мэдээ өгөх зэрэг тус тусын үйл ажиллагааг зохион байгуулж тайлан мэдээг нэгтгэж үндэсний хэмжээнд зохион байгуулсан.	
1.4	Осол гэмтлийн тандалтын мэдээний үр дүнд үндэслэн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах	Дотоо д нөөц болом ж	Зохион байгуулсан сургалт сурталчилгаа, постер	Осол гэмтлийн тандалт, судалгааны тоон мэдээнд үндэслэн цахим болон цаасан хэлбэрээр мэдээлэл сургалт сурталчилгааг тогтмол явуулж хэвшсэн.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	- Цаг үетэйгээ холбогдуулан осол гэмтлийн талаарх урьдчилан сэргийлэх постеруудыг хийж ГССҮТ-ийн болон албаны пэйж хуудсанд байршуулан цахимаар иргэдэд мэдээллийг тогтмол хүргэсэн. Нийт 150 гаруй төрлийн постерийг цахимаар иргэд, олон нийтэд хүргэсэн байна. Энэ нь 11000 хандалт, 802 шэйр авсан байна. Үүнд: ✓ Болзошгүй гамшиг ослоос сэргийлэх чиглэлээр ✓ Ахуйн ослоос сэргийлэх чиглэлээр 150 төрлийн зурагт хуудас ✓ Баяр наадмын олон хоногийн амралтын үед урьдчилан сэргийлэх чиглэлээр аялал зугаалгаар явахдаа анхаарах зүйлс, архидалт, зам тээврийн осол, үер усны	100%

						аюул, наршилт, осол гэмтэл, ковид зэрэг нэн чухал сэдвүүдээр нийт 25 төрлийг постерийг бэлтгэж ГССҮТ-ийн пейж хуудаст байршуулж мэдээллийг олон нийтэд хүргэсэн. (2250 хандалт авч 415 удаа шэйр). “Хүүхдийг ахуйн осол гэмтэлд өртөж хохирохоос урьдчилан сэргийлье” "Намайг анхаараарай" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн албаны мэргэжилтэн Б.Сувд-эрдэнэ Багануур дүүргийн цагдаагийн хэлтэст ярилцлага өгсөн. - Arslan.mn сайтад НЭМАлбаны мэргэжилтэн баяр наадмын өдрүүдийн осол гэмтэл, хүчирхийллийн талаарх нөхцөл байдлыг танилцуулж иргэдэд сэрэмжлүүлэг мэдээллийг шууд дамжуулан хүргэсэн.	
1.5	Хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч нарт чиглэсэн сургалтын модуль багц боловсруулах	ЭМ-ийн Дэмжих сан	Боловсруулсан сургалтын модуль багц	Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төслүүд хэрэгжүүлж хэвшсэн.	Хүүхэд, эцэг эхчүүд осол гэмтлээс сэргийлэх талаар цогц мэдээлэлтэй болно. Сургагч багшаар дамжуулан мэдээллийг олон нийтэд түгээнэ.	Монгол улсын Засгийн газрын 2019 оны “Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр-III”, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/167 дугаар тушаал, Эрүүл мэндийг дэмжих сангийн 2021 оны 02 дугаар тушаал, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ГССҮТ-ийн ерөнхий захирлын А/123 тоот тушаал гарч “Хүүхдийг осол, гэмтлээс сэргийлэх хүүхэд, эцэг эх,	100%

						асран хамгаалагч нарт чиглэсэн сургалтын модуль багц боловсруулж, сургалт зохион байгуулах” удирдамжийн дагуу модуль боловсруулах, санал хэлэлцэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажилласан. 1. Түлэгдэлт 2. Уналт 3. Хахах 4. Зам тээврийн осол 5. Хүчирхийлэл гэсэн 5 чиглэлээр видео, сорил, сургалт мэдээлэл, ном гарын авлага гэсэн 4 хүрээнд сургалтын интерактив багцыг хүүхэд, эцэг эхчүүдэд зориулан боловсруулж хийсэн. Интерактив сургалтын модуль багц нь дараах хоёр бүлэгт чиглэсэн : • Хүүхдэд зориулсан интерактив сургалтын багц • Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан интерактив сургалтын багц • Интерактив сургалтын модуль багц тус бүр нь түлэгдэлт, уналт, хахалт, зам тээврийн осол, хүчирхийлэл гэсэн үндсэн 5 чиглэлээр видео, илтгэл хичээл, ном гарын авлага, сорил гэсэн 4 хүрээнд сургалтын эх материалыг боловсруулж хоёр интерактив сургалтын модуль багцыг хийсэн.	
--	--	--	--	--	--	--	--

						Хүүхэд, насанд хүрэгчдэд зориулсан интерактив сургалтын модуль багцыг ашиглан нийслэлийн Сонгино-хайрхан, Багахангай, Багахангай, Налайх, Хан-уул дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн төлөөлөл болсон 400 багш, эмч, нийгмийн ажилтан нарт сургагч багшаар бэлтгэх сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулж интерактив сургалтын модуль багцыг танилцуулсан.	
ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ							
2.1	Магистр, докторын зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлнэ		Нийт эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн 8% магистрын зэрэг, эмч нарын 2% докторын зэрэг шинээр хамгаална.	Нийт эмч, сувилагч нарын 46.7% нь магистрын зэрэгтэй байна. Нийт эмч нарын 1 нь АШУДоктор, 2 нь АУДокторын зэрэгтэй байна.	Нийт эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн 54.7% нь магистрын зэрэгтэй, нийт эмч нарын 2 хувь /3 эмч/ нь докторын зэрэгтэй болсон байна.	- Тайлант онд нийт 14 эмч эмнэлгийн мэргэжилтэн доктор, магистрын зэрэг хамгаалсан. Үүнд: 1 эмч буюу нийт эмч нарийн 2% нь АУДокторын зэрэг хамгаалсан байна. 7 Эмч буюу нийт эмч нарын 5% нь, 2 мэргэжилтэн буюу нийт мэргэжилтний 3% нь, 2 сувилагч буюу нийт сувилагчийн 1% нь, 2 тусгай мэргэжилтэн буюу нийт тусгай мэргэжилтний 3% нь байна. 14 сувилагч бакалаврын зэрэг буюу дипломын зэрэгтэй сувилагчийн 20% нь баклаврын зэрэг тус тус хамгаалсан байна.	90%

2.2	Эмнэлгийн ажилтнуудын харилцаа хандлага, ёс суртахууныг сайжруулах хөтөлбөр боловсруулна.	4 сая	Ажилтнуудын харилцаа, хандлага, ёс суртахууны зөрчлийн тоог 5%-иар, үйлчлүүлэгчдийн өргөдөл, гомдлын тоог 20%-иар бууруулах ба үйлчилгээний соёл, ажилчдын харилцаа хандлагад өгсөн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг 25%-иар дээшлүүлэх.	2020 онд үйлчлүүлэгчдээс ирсэн өргөдөл, гомдол 43, сахилгын шийтгэл 31 ажилтан авсан.	Ажилтнуудын харилцаа, хандлага, ёс суртахууны зөрчлийн тоо 5%-иар, үйлчлүүлэгчдийн өргөдөл, гомдлын тоо 20%-иар буурч, үйлчилгээний соёл, ажилчдын харилцаа хандлагад өгсөн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ 25%-иар нэмэгдсэн байна.	• Эмнэлгийн ажилтнуудын харилцаа хандлага, ёс зүйг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд: Нийт 8 үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлэн ажилласан байна. • 2021 онд салбар хороонд ирсэн 6 гомдлын 2-ыг эвлэрүүлэн зуучилсан, үйлчлүүлэгчээс ирсэн 1 зөрчилд холбогдох материал, тайлбарыг гаргуулан Ёс зүйн хяналтыг хороонд хүргүүлсэн, ёс зүйн зөрчил илэрсэн 2 тохиолдолд ЭМС-ын А/406, А/256 тоот тушаалын дагуу салбар хороо хуралдан, дүгнэлт гарган захиргаанд санал хүргүүлсэн болно. Ёс зүйн зөрчлийн улмаас 2021 онд нийт 2 эмч, эмнэлгийн ажилтанд ерөнхий захирлын 2021 оны Б/406, Б/407 тоот тушаалаар сахилгын шийтгэл ноогдуулсан. • Ажилтнуудын харилцаа, хандлага, ёс суртахууны зөрчлийн тоо өмнөх онтой харьцуулвал 5%-иар буурсан үзүүлэлттэй байна. • ГССҮТ-ийн Ерөнхий захирлын 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/12 дугаар тушаалаар 2021 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанд биечлэн, бичгээр, цахим, 11-11 төвөөр	100%
-----	---	-------	--	---	--	---	------

						нийт 1838 талархал, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч 100% шийдвэрлэн ажилласан. Талархал: • Бичгээр – 11 • Цахимаар- 11 • Утсаар -2 • 11-11 төвөөр -2 Хүсэлт: • Бичгээр ирсэн- 35 • Цахимаар – 1675 Гомдол: • Бичгээр – 13 • Биечлэн – 7 • Цахимаар – 33 • Утсаар- 13 • 11-11 төвөөр -11 Өргөдөл: • Бичгээр- 13 Санал: • Цахимаар – 3 • Утсаар – 9	
2.3	Байгууллагын соёлыг төлөвшүүлэх манлайллын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	17.5 сая	Батлагдсан хөтөлбөр	-	Төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжсэн байна.	• Байгууллагын соёлыг төлөвшүүлэх манлайллын хөтөлбөрийн хүрээнд: Нийт 7 үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлэн ажилласан байна. ✓ Тайлант онд эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, байгууллагын болон хувь хүний соёл, хөгжил манлайлал, бусад чиглэлээр нийт 12 удаагийн сургалт зохион, байгуулсан. Нийт 446 эмч, эмнэлгийн ажилтнууд хамрагдсан. ✓ Ажилтан бүр өөрийн байгууллагын үнэт зүйл,	100%

						алсын хараа, эрхэм зорилгыг мэддэг болох аяны хүрээнд “Захиргаа, хүний нөөцийн алба”-ны фэйсбүүк хуудсанд байгууллагын үнэт зүйл, алсын хараа, эрхэм зорилгыг байршуулан ажиллаж байна. Мөн Захиргаа, хүний нөөцийн албанаас ажилтнуудад өгч байгаа мэдээллээ нэгтгэж “Шинэ ажилтны гарын авлага” номыг гарган цахим болон хэвлэмэл байдлаар ашиглаж байна. Энэхүү гарын авлагат А/406 тушаалын дагуух эрх үүргүүдийг 1 бүлэг болгон оруулж шинээр орж буй ажилтнуудад танилцуулж хэвшсэн. ✓ Шинэ ажилтныг дасан зохицуулах сургалтын хөтөлбөр"-ийг боловсруулж Ерөнхий захирлын 2018 оны А/398 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрт байгууллагын түүхэн замнал, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, хөдөлмөрийн дотоод журам, эмч, эрүүл мэндийн байгууллагын ёс зүйн журам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аюулгүй байдлын талаартанилцуулж, эхнээс нь шинэ ажилтнуудаа чиглүүлж ажиллаж байгаагаас ажилдаа амархан	
--	--	--	--	--	--	---	--

						дадлагажиж, ажлын чадамж, гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмж сайтай, тогтвор суурьшилтай, хариуцлагатай ажиллаж байна. Байгууллагын соёл, ажилтны багаар ажиллах төлөвшилт, хандлагад эерэгээр нөлөөлж байна. Шинэ ажилтанд зориулсан чиглүүлэх сургалтанд 2021 онд нийт 55 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан нь нийт шинээр орсон ажилтнуудын 90 хувь хамрагдсан байна. “Шинэ ажилтны чиглүүлэх сургалт”-ыг шинээр ажилд томилогдож байгаа болон урт хугацааны чөлөө, жирэмсний, хүүхдээ асрах чөлөө нь дуусч ажилдаа томилогдож байгаа эмч, эрүүл мэндийн ажилтан бүрт танилцуулан, мэдлэгийг нь бататган ажиллаж хэвшсэн. Үүнд: Байгууллагын танилцуулга, ХАБЭА, хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ зэргийг ЗХНА, Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын талаар ЭТҮЧАлба, Сувилахуйн тусламж үйлчилгээний чанарын талаар Сувилахуйн албаны дарга болон арга зүйч нар мэдээллийг шинэ ажилтан	
--	--	--	--	--	--	---	--

						ажилд томилогдохоос өмнө өгч хэвшсэн. ✓ Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор ЭМС-ын А/406 тушаалын дагуух эрх үүргүүдийг цахимаар сурталчилах, соён гэгээрүүлэх аяны хүрээнд “Захиргаа, хүний нөөцийн алба”-ны фэйсбүүк группд байгууллагын үнэт зүйл, эрхэм зорилгыг байршуулан ажилласан. ✓ Олон улсын сувилагч нарын баярын өдрийг угтан Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Ёсзүйн салбар хороотой хамтран “Бие биедээ урам өгье” цахим талархлын аяныг зохион байгуулж сувилагч, тусгай мэргэжилтнүүддээ мэндчилгээ, урмын сайхан үг илгээж ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх аянг зохион байгуулсан. Энэхүү аяны хүрээнд хамгийн их хандалт авсан сувилагч, тусгай мэргэжилтнийг шалгаруулж,урамшуулан цахим хуудсаар дамжуулан алдаршуулав. ✓ ГССҮТөвийн Захиргаа, хүний нөөцийн албаны фэйсбүүк хуудаст Эрүүл Мэндийн Сайдын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний	
--	--	--	--	--	--	--	--

						өдрийн А/406 тушаалаар шинэчлэн батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийг эмч, эмнэлгийн ажилтнуудад танилцуулах зорилгоор “Дэглэмээ сахъя-Дүрмээ судалъя” цахим цуврал постерийг жилийн турш 7 хоног тутам цувралаар нийтлэн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтэнд хүргэж, танилцуулан ажилласан. ✓ Гэмтэл согог судлалын үндэсний төвийн сувилагч, тусгай мэргэжилтний ажлын байран дахь стресс, дарамт шахалтыг үнэлэх эрсдэлийн үнэлгээг АНУ-ийн Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын агентлаг /OSHA/-аас боловсруулсан “Эрүүл мэндийн байгууллагын ажилчдын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ”-ний аргачилсан зөвлөмжийг ашиглан хийсэн. Ажлын байран дахь стрессийг үнэлэх-15, дарамт шахалтыг үнэлэх-15, ерөнхий-6 асуумж бүхий нийт 36 асуумжаар эрсдэлийн үнэлгээ, судалгааны үр дүнг боловсруулсан. /Судалгааг тайланд хавсаргав/ Ажлын байран дахь стресс, дарамт шахалтыг илрүүлэх эрсдэлийн үнэлгээгээр нийт	
--	--	--	--	--	--	---	--

						үнэлгээнд хамрагдсан сувилагч, тусгай мэргэжилтний 64%-д нь стрессийн түвшин дунд ба түүнээс их, 48%-д нь дарамт шахалтын түвшин дунд буюу түүнээс их үнэлгээтэй гарсан. Энэхүү эрсдэлийн үнэлгээ нь based on self risk assessment буюу хувь хүн өөрийгөө үнэлэхэд тулгуурлан хийгдсэн буюу асуумж бүрт хувь хүн өөрийн зүгээс хариултыг өгдөг. Гэвч эрсдэлийн үнэлгээний үр дүнгээр 48%-д нь дарамт шахалтын түвшин дунд буюу түүнээс их үнэлгээтэй гарсан ч үнэлгээнд хамрагдсан нийт сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн 23.4% нь буюу тал хувь нь л хэн нэгэн /албан тушаалтан/-ээс дарамт шахалт ирдэг гэж хариулсан. Энэ нь зарим ажилчдад ажлын байран дээрх хүчирхийлэл, дарамт шахалтын талаарх ойлголт мэдлэг дутмаг эсвэл аливаа үнэн бодит мэдээллийг удирдлагад мэдээллэх байдал дутмаг байгааг илэрхийлж болох юм. Ажлын байран дахь стресс, дарамт шахалтыг илрүүлэх эрсдэлийн үнэлгээгээр нийт үнэлгээнд хамрагдсан сувилагч, тусгай мэргэжилтний 64%-д нь	
--	--	--	--	--	--	---	--

						стрессийн түвшин дунд ба түүнээс их, 48%-д нь дарамт шахалтын түвшин дунд буюу түүнээс их үнэлгээтэй гарсан тул байгууллагын удирдлагын баг 186 сувилагч тусгай мэргэжилтэнтэй нэг бүрчлэн уулзаж тулгамдаж буй асуудлуудыг үе шаттайгаар шийдвэрлэн ажилласан.	
2.4	Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадварын зэргийг нэмэгдүүлнэ.	-	Мэргэжлийн ур чадварын ахлах зэргийг 2%-иар, тэргүүлэх зэргийг 1%-иар, зөвлөх зэргийг 0.5%-иар тус тус нэмэгдүүлэх	Нийт эмч нарын 50,3% нь, сувилагч нарын 29,6% нь мэргэжлийн зэрэгтэй.	Ахлах зэргийг 2%-иар, тэргүүлэх зэргийг 1%-иар, зөвлөх зэргийг 0.5%-иар тус тус нэмэгдүүлсэн байна.	Гэмтэл согог судлалын үндэсний төвийн хэмжээнд 2021 оны 01 дүгээр сард 65 эмч, эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн зэрэг хамгаалсан байна Үүнд: Их эмч: Зөвлөх зэрэг -2, Тэргүүлэх -1, Ахлах - 11 Сувилагч тусгай мэргэжилтэн: Зөвлөх зэрэг -4, Тэргүүлэх -26, Ахлах -21 Тус тус хамгаалсан нь Нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 19% нь мэргэжлийн зэрэг хамгаалсан байна.	100%
2.5	Ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулна.		Батлагдсан хөтөлбөр	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөг Ерөнхий захирлаар 2020 оны 01 сарын 05-ний өдөр батлуулж нийт 26 ажлыг хэрэгжүүлэн ажилласан байна.	Хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилт 80 хувиас доошгүй байна.	Эрүүл мэндийн сайдын А/548 тоот тушаалын дагуу эмч, ажилтнуудад унаа хоолны зардалд ажлын 1 өдөрт 5000 төгрөгөөр тооцон нийт эмч ажилтнуудад 314.1 сая төгрөгийн унаа хоолны зардал олгосон. Ээлжээр ажиллаж байгаа эмч эмнэлгийн ажиллагсдад өглөө, өдөр, оройн хоолыг үнэ төлбөргүй олгож байна.	100%

						• Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны цалинг Засгийн газрын тогтоолоор баталсан ТҮЭМ, ТҮ-ийн албан хаагчийн цалингийн жишгээс бууруулаагүй ба Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоол болон төр, захиргааны дээд байгууллагуудаас гарсан хүчинтэй тушаал, журмыг үндэслэн албан тушаалын, эрдмийн ба мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын нэмэгдэл, нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны сайдын тушаалд заагдсан хүнд, хортой нөхцөлд ажиллаж байгаа эмнэлгийн ажилтнуудад тус журамд заасны дагуу хөнгөлөлт эдлүүлж байна. • Ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв шударгаар дүгнэх зорилгоор Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний загвар, аргачлалыг шинэчлэн боловсруулж, Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны 06 дугаар сарын 09-ны А/59 тоот тушаалаар батлан мөрдөж, засгийн газрын тогтоолын дагуу нэмэгдэл, мөнгөн урамшууллыг болзлын дагуу дүгнэн улирал тутам үндсэн цалингийн 10-20 хувийн урамшуулал олгож байна. • Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг тасгийн эрхлэгч, албадын	
--	--	--	--	--	--	--	--

						дарга нар шалгуур үзүүлэлтээр үнэлэн, ажил дүгнэх комисс эцсийн дүгнэлт гаргадаг. Урамшуулалт цалинг 1 дүгээр улиралд 658 хүнд 249.9 сая төгрөгийн урамшуулал олгосон. • Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйл, хөдөлмөрийн дотоод журмын дагуу нийт 29 ажилтанд чөлөө олгосон, үүнээс цалинтай чөлөө 24 ажилтанд, цалингүй чөлөө 5 ажилтанд олгосон. • 50 дугаар зүйлийн дагуу 20 ажилтанд хавсран ажилласны нэмэгдэл хөлс олгож байна. • Хөдөлмөрийн тухай хуулийн 106 дугаар зүйлийн дагуу 9 эхэд жирэмсний болон амаржсаны, хүүхэд асрах чөлөөг олгосон. Мөн хуулийн 35 дугаар зүйлд зааснаар ажил, албан тушаалыг нь хэвээр хадгалж, хүсэлтээ гаргасан 8 эхийг ажилд томилсон. • Эрүүл мэндийн байдлаас шалтгаалан хөдөлмөрийн чадвараа түр алдсан 433 (давхардсан тоогоор) ажилтанд эмнэлгийн хуудсаар чөлөө, мөнгөн тэтгэмж олгож, шинэ хүүхэдтэй болсон 6 ажилтанд хөдөлмөрийн хууль, дотоод журамд заасны дагуу аавын 5 хоногийн цалинтай чөлөөг тус тус олгосон. (2021.11.30-ны өдрөөр) • Хөдөлмөрийн дотоод журмын 8.3.2 дах заалтын дагуу Эрүүл мэндийн шалтгаанаар (хорт	
--	--	--	--	--	--	--	--

						хавдар) удаан хугацааны эмчилгээ шаардлагатай болсон 3 сувилагч, 1 тусгай мэргэжилтэнд тус бүр 500,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. • Хөдөлмөрийн дотоод журмын 8.3 дах заалтын дагуу аав, ээж, ах, эгч, дүү нь өөд болсон 45 ажилтанд нийт 8.3 сая төгрөгийн тэтгэмж олгосон. • Ковид-19-өөр өвдсөн ажилтнуудынхаа дархлааг дэмжих зорилгоор гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн 2021 оны 08 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу ковид 19 халдавын үед хэрэглэх эмийн эмчилгээ, дархлаа дэмжих багц бүтээгдэхүүнийг 463 эмч, эмнэлгийн ажилтнуудад олгосон. • Хөдөлмөрийн хүнд хортой нөхцөлийн нэмэгдлийг нийт 361 эмч, эмнэлгийн ажилтнуудад 293,6 сая төгрөг олгосон. • Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг (10-20 хувь) нийт 174 эмч, эмнэлгийн ажилтнуудад олгож байна • Тэнгэрийн модун ХХК-с хандивласан дархлаа дэмжих бүтээгдэхүүнийг Коронавируст халдвар цар тахлын хүнд нөхцөлд албан үүргээ нэр хүндтэй гүйцэтгэж байгаа нийт 105 асрагч, шил угаагч, угаагч, цахилгаанчин, слесарь нарт олгосон. • Тус эмнэлгээс 110 эмч эмнэлгийн ажилтнуудыг шагналд тодорхойлж холбогдох газрууд руу	
--	--	--	--	--	--	--	--

						материалуудыг илгээсэн. Үүнээс 90 эмч, эмнэлгийн ажилтны шагнал ирсэн ба дагалдах 5.300.000 төгрөгийн мөнгөн урамшууллыг холбогдох журмын дагуу олгосон. • Олон улсын сувилахуйн мэргэжилтний өдрийг тохиолдуулан Гэмтэл согог судлалын үндэсний төвийн нийт сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн ажил үүргийн онцлогийг таниулах, алдаршуулах, Ковид-19 цар тахлын энэ цаг үед сэтгэл зүйг нь дэмжих, ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх үүднээс 2021.05.01 - 2021.05.10-ны өдрийн хооронд “Сувилахуйн мэргэжилтний манлайлал-2021” фото зургийн уралдааныг Захирлын ажлын алба, Халдварын сэргийлэлт, хяналтын албатай хамтран амжилттай зохион байгуулж шилдгүүдээ тодруулсан. Фото зургийн уралдаанд тасаг албадаас 33 бүтээл ирүүлснээс сэдэв тус бүрээс 1, 2-р байрыг шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналыг гардууллаа. • Мобиком ХХК-аас хамтын ажиллагааны хүрээнд манай төвийн 140 эмч, эмнэлгийн ажилтнуудад 2021 оны 01 дүгээр сараас эхлэн сар бүр 10 гб дата үнэ төлбөргүй өгч байгаа. • Дэлхий дахинд үүсээд байгаа цар тахалтай холбоотойгоор хүн бүр өөр өөрийн өдрийн цай, хоолоо гэртээ бэлдээд,	
--	--	--	--	--	--	--	--

						эрүүл мэндийн чанарын шаардлага хангасан сав суулганд зөөвөрлөн хэрэглэж хэвших нь өөрийн болоод хайртай дотнын хүмүүсийнхээ эрүүл мэндэд хөрөнгө оруулж буй хамгийн зөв сонголт тул төвийн 326 сувилагч тусгай мэргэжилтнүүдэдээ нэг удаагийн хэрэглээнээс татгалзаж чадах бүтээгдэхүүнүүд буюу ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцоогоор баталгаажсан хоолны халуун савыг хамтран ажиллагч байгууллагын дэмжлэгээр авч өгсөн. Хүн бүр нэг удаагийн аяганы оронд дахин ашигладаг аяга хэрэглэснээр жил бүр 9 сая мод тайрагдахаас сэргийлж чадах юм. • УИХ гишүүн Х.Ганхуяг дэмжлэг үзүүлж цар тахлын хүнд нөхцөлд цаг наргүй ажиллаж байгаа 60 эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд гарын бэлэг гардууллаа. • ГССҮТөвийн ҮЭ-хороотой хамтран УИХ гишүүн Ж.Ганбаатар төвийн 326 сувилагч, тусгай мэргэжилтэнүүдэд "Олон улсын сувилагчдын өдөр"-ийн мэндийг хүргэж, 20000 төгрөгийн эрхийн бичиг гардуулсан. • ГССҮТ-ийн Захиргааны зүгээс Хас банктай хамтран ажиллах ерөнхий гэрээнд заагдсан цалингийн зээлийн хүүг бууруулах хүсэлт гаргасныг ХАС банк хүлээн авч зээлийн хүүд өөрчлөлт оруулсан. Үүний
--	--	--	--	--	--	---

						дүнд цалингийн зээлийн сарын хүү 1,4% байсныг 1,2% болгон бууруулсан. Мөн төвийн удирдлагын зүгээс ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотойгоор хэрэгжүүлж байгаа орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд Соргог баян далай ХХК-ны ШҮҮТ хотхоноос байр авах ажилтнуудын хүсэлтийг тэргүүн ээлжинд хүлээн авч шалгуур хангасан ажилтнуудад Банкны эх үүсвэрээр 6 хувийн Орон сууцны зээлийг шийдвэрлэн 15 эмч, эмнэлгийн ажилтныг зах зээлийн ханшнаас доогуур үнээр орон сууцанд хамруулж тулгамдаж буй нийгмийн асуудлыг шийдэрлэсэн. • Нийгмийн хариуцлагын хүрээнд "Enica Organic Imprex" ХХК-ийн хамт олон Эника брэндийн 11 нэр төрлийн дархлаа дэмжих бүтээгдэхүүнийг Ковид-19 цар тахлын үед ажиллаж буй 770 эмч, эмнэлгийн ажилтнуудад өгснийг тасгийн ахлах сувилагч, албадын дарга нараар дамжуулан олгосон. • Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сарын аяны хүрээнд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа НХГСТасгийн асрагч Г.Болортуяа, ААХҮАлбаны мужаан М.Дэнзэн, ЭЭТасгийн асрагч Б.Дугармаа, ТНСМЗТасгийн сувилагч Н.Туяа, ГСНСБМЗТасгийн сувилагч Ц.Алтантөгс нарын 5
--	--	--	--	--	--	---

						ажилтанд 5 ханатай өргөө цагаан гэр гардуулж өгсөн. • Элсэлтийн ерөнхий шалгалтаа амжилттай өгч, Анагаахын ухааны их дээд сургуульд элсэн орсон тус төвийн ЭТҮХДэд захирал Р.Гантуяагийн охин Г.Номундарь, Нэгдсэн лабораторийн тасгийн Лаборант Д.Түмэнхүүгийн охин Х.Солонго, ТНСМЗТасгийн туслах сувилагч Ш.Аззаяагийн охин Г.Жаргал нарт оюутны сургалтын төлбөрт нь дэмжлэг үзүүлэн тус бүр 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. • Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж нийт эмч, ажилчдын 4-12 насны хүүхдүүдийн дунд “Хамтдаа сэргийлье” сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулж 45 хүүхэд оролцож шилдэг бүтээлүүдийн эздийг тодруулан шалгарсан бүтээлүүдэд Unitel компани гарын бэлэг ирүүлсэн ба уралдаанд оролцсон бүх бяцхан оролцогч нартаа зохион байгуулагчдын зүгээс гарын бэлгээр урамшуулсан. • Эмч, ажилтнуудын нийгмийн хамгааллыг дэмжих, эрүүл мэндийг нь хамгаалах зорилгоор “Эмч, ажиллагсдын эрүүл мэндэд тогтмол хяналт тавих, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээнд хамруулах” ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Ерөнхий захирлын 2021 оны	
--	--	--	--	--	--	---	--

						A/111 тоот тушаалаар батлан зохион байгуулласан. (Тайланг хавсралтаар хүргүүлэв). • Нэгдсэн угаалгын тасаг нь нэг чиглэлийн урсгалтай, бохир материалыг хүлээн авах, ангилан ялгах, угаах, хатаах, индүүдэх, боох, бэлтгэх, хадгалах, болон угаалгын тасгийн ажилтны хувцас солих, амралтын өрөөтэй болсон. Орчин үеийн тоног төхөөрөмжөөр “хятад улсад үйлдвэрлэсэн 50 кг багтаамжтай ХТQ-50 маркийн угаалгын машин, SWA801-50 маркийн хатаагч машин”-аар тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан ажиллаж байна. • Төвлөрсөн ариутгалын тасаг нэгж нь ариутгагч нарын гадна хувцсаа солих, амрах тав тухтай нөхцөл байдлаар хангагдсан өрөөтэй болсон. Мөн халдварын сэргийлэлт, хяналтын ахлах сувилагчийн өрөөг засварт оруулж гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай, ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. • Тендер зарлаж тендерт “Бако констракшн” ХХК шалгарч 198.2 сая төгрөгөөр 2647м² дээвэрт их засвар хийсэн. Үүнд: Нэгдсэн угаалга, дизкамер, Шүүх эмнэлэг, Гражууд, ТНСМЗТасгийн дээвэр, Архивын дээвэр зэргийг иж бүрэн засварласан. • Шүүх эмнэлгий 405м² талбай дахь өрөө, тасалгаа, коридорт засвар хийж ажилчдын ажлын байрны нөхцөл сайжирсан.	
--	--	--	--	--	--	---	--

2.6	Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлнэ	-	Шинээр ажиллан суралцах арга хэмжээнд хамрагдсан эмч мэргэжилтний тоо	2020 онд ГССҮТөвөөс Увс аймагт 8, Говьсүмбэр аймагт 4 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлсэн	Ажиллан суралцах эмч мэргэжилтний тоог 20 хувиар нэмэгдүүлсэн байна	• Эрүүл мэндийн ажилтны тасралтгүй суралцах, өсч хөгжих эрмэлзлэлийг идэвхитэй дэмжин, ажиллангаа сурах, мэдлэг ур чадварыг бий болгох таатай нөхцлийг олгож ирсэн. Тухайлбал бид эрүүл мэндийн ажилтнуудаа байнгын сургалтанд хамруулж, үр дүнтэй, бүтээмжтэй ажиллах ур чадварыг эзэмшүүлж ирсэн. Үүнд: Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7, 61.1.10 дах заалтын дагуу ажлаас 1-6 сараас хугацаатай чөлөөлж, цалинг олгож нийт 7 эмч, сувилагч, мэргэжилтний ажил үүрэгт зохицуулалт хийж ажилласан. 1. Төрийн сангийн зээлээр нийт 43 эмч эмнэлгийн ажилтныг сургаж ажил үүрэгт зохицуулалт хийж ажиллаж байна. 2. Мэргэшүүлэх сургалт нийт 12 Үүнд: • Гар сарвуу нөхөн сэргээх бичил мэс засал судлал-3 • Үе бүтээх солих мэс засал судлал-3 • Доод мөчний нөхөн сэргээх мэс засал судлал-2 • Нурууны мэс засал судлал-4 • Түлэнхий хөлдөлт судлал-10 • Хүүхдийн гэмтэл согог судлал-2 • Цээж хэвлийн гэмтэл согог судлал-2 • Диализийн сувилахуй-2 • Диализийн техникч-1 • Диализийн эмч-2	100%
-----	--	---	---	---	---	--	------

						• Хэвлийн дурангийн мэс засал судлал-1 • Бөөрний мэс засал судлал-1	
2.7	Шинээр нэвтрүүлсэн технологи, өвчний оношлогоо, эмчилгээний төрлөөр өндөр хөгжилтэй оронд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг багаар нь суралцуулна	60 сая	Гадаад сургалтад хамрагдсан хүний тоо	Онцгой байдал зарлаж улсын хил хаасан учир гадаад сургалт тодорхойгүй хугацаагаар хойшилсон. Тайвань улсын эрүүл мэндийн мэргэжилтний сургалтын төвийн 1 сарын сургалт цахим хэлбэрээр зохион байгуулагдсан.	Төлөвлөгөөн ий дагуу сургалтад хамрагдсан байна.	• Цахим хэлбэрээр дараах сургалтанд эмч, эмнэлгийн ажилчид тус тус хамрагдсан. • 2021 оны 1 сарын 28-нд Гэмтэл согогийн тусламж үйлчилгээний тулгамдсан асуудлын нэг Нурууны дурангын мэс засал, төрөлхийн нурууны мурийлтын оношилгоо, эмчилгээ, мэс заслын заалт сэдвээр цахим сургалт зохион байгууллаа. ✓ Endoscopic spine surgery JIAN HUA CHEN/Yuan Rung Medical System/Yuan Sheng Hospital ✓ Congenital Scoliosis and idiopathic adolescent scoliosis its conservative and surgical management and indications JIAN FU CHENG/ Yuan Rung Medical System/Yuan Sheng Hospital нар уншив. • Мөн анх удаа 5G төхөөрөмж ашиглан төрөлхийн шалтгаан тодорхойгүй нурууны мурийлт гэсэн оноштой 3 өвчтөнийг үзэж, санал бодлоо хуваалцан, оношилж, эмчлүүлэгдчийн цаашдын эмчилгээний асуудлыг шийдвэрлэвКовид-19 халдварын нөхцөл байдлын улмаас улсын хил хаасан учир гадаад сургалт тодорхойгүй хугацаагаар хойшилсон.	

						• 2021 оны 04 дүгээр сарын 22-ний өдөр Тайван улсын Yung Rung эмнэлгийн Гэмтлийн тасгийн эрхлэгч Ren-De, Chen, гэмтлийн эмч Jian-Fu, Chen нартай хамтран ГССҮТөвийн НХГСТасгийн эмч Д.Энхтүвшин, Т.Отгонболд, Э.Ниндэвдэмбэрэл,Б.Батсүх, сувилагч П.Жавзандулам, Мэдээгүйжүүлгийн эмч Г.Ариунболд, мэдээгүйжүүлгийн сувилагч П.Хулан нарын бүрэлдэхүүнтэй мэс заслын баг Зүүн өвдөгний дотор жийргэвч мөгөөрсний арын эвэр хэвтээ урагдалтай үйлчлүүлэгчид дурангийн мэс заслыг анх удаа 5G хурдтай ухаалаг нүдний шил ашиглан алсын зайнаас харилцан ярилцаж, зөвлөлдөж, туршлага солилцон уг мэс заслыг амжилттай хийсэн.	
--	--	--	--	--	--	---	--

2.8	Үндсэн мэргэшлийн сургалтыг дүрэм журмын дагуу зохион байгуулна.	5 сая	Үндсэн мэргэшлийн сургалтад хамрагдсан хүний тоо	2020 онд 13 резидент суралцаж төгссөн. 2020 оны 09 сарын 22-ны өдрийн “Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын хяналтын тоог шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайдын А/440 тоот тушаалаар Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвд 30 суралцагч сургах орон тоо батлагдсан	Сургалтыг дүрэм журмын дагуу зохион байгуулна.	• 2020 оны Эрүүл мэндийн сайдын А/491 тоот тушаал, ГССҮТ-ийн ерөнхий захирлын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/140 тоот тушаалаар батлагдсан нийт I болон II курсийн 63 резидент эмч суралцаж байна. • 2021 онд төгсөх курсийн 24 резидент эмч төгсөлтийн шалгалт өгснөөс 3 эмч шалгалтаа хангалтгүй өгч 3 сар дахин дадлага сургалтад хамрагдаж байж дахин шалгалтад орохоор болсон. Шалгалтаа амжилттай өгсөн 21 резидент эмч ЭМСайдын 10 дугаар сарын 25-ний өдрийн А/640 тоот тушаалын дагуу амжилттай суралцаж төгссөн.	90%
2.9	Төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтыг дүрэм журмын дагуу зохион байгуулна	5 сая	Элсэгч болон төгсөгч нарын тоо	2020 онд 38 эмч амжилттай суралцаж төгссөн. 7 чиглэлд нийт 70 суралцагч сургах боломжтой 2021 онд их эмч амжилттай суралцаж төгссөн	Сургалтыг дүрэм журмын дагуу зохион байгуулна.	• Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотой төгсөлт болон хаврын элсэлт хүртэл хойшилсон. 2021 оны 10 дугаар сарын ЭМСайдын А/653 тоот тушаалаар суралцах чиглэл батлагдсан 38 их эмч 7 чиглэлээр суралцаж төгссөн.	100%
2.10	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо ISO 45001 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.	30 сая	Үйл ажиллагааны төлөвлөгөө	-	Төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжсэн байна.	Гэмтэл согог судлалын үндэсний төвийн ажилчдын хөдөлмөрийн нөхцөл, ажлын ачааллыг тодорхойлж, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээг боловсруулах зорилгоор АШУҮИС-ийн НЭМС-ийн Хөдөлмөр, Орчны эрүүл ахуйн	90%

						тэнхимтэй хамтран ажлын байрны эрүүл ахуйн үнэлгээ хийсэн. Дүгнэлт: - Агаарын температур Ажлын байрны агаарын температурын хэмжилт хийсэн ажлын 4 байранд агаарын дундаж температур 20.1-21.7°C тодорхойлогдсон нь MNS4990:2015 стандартад заасан хэмжээ (22-28°C)-нээс бага, ажлын хоёр байранд 28.8-35°C байсан нь стандарт (22-28°C)-аас давсан байна. Хоёр ажлын байрны агаарын дундаж температур 26.9-27°C байсан нь MNS4990:2015 стандартын ажлын зэрэглэлийн 16 бүлэгт заасан хэмжээ (22-26°C)-нээс давсан нь ажлын орчны эрүүл ахуйн шаардлагыг хангахгүй байна. - Агаарын харьцангуй чийглэг Ажлын байрны агаарын харьцангуй чийглэгийг хоёр ажлын байранд 60.2-65.8% тодорхойлогдсон нь MNS4990:2015 стандартад заасан тохиромжтой хэмжээ (30-60%)-ээс хэтэрсэн байгаа нь ажлын орчны эрүүл ахуйн шаардлагыг хангахгүй байна. - Агаарын хөдөлгөөн Ажлын байран дахь агаарын урсгалын хурд 13 байрлалд 0.3-1.9м/сек байсан нь MNS4990:2015 стандартад заасан 1а зэрэглэлийн хэмжээ (0.1-0.2м/сек)-ээс их байна. Харин 5 байрлалд агаарын урсгалын дундаж хурд 0.4-2.6м/сек байсан нь	
--	--	--	--	--	--	---	--

						MNS4990:2015 стандартын 16 бүлэгт заасан хэмжээ (0.1-0.3м/сек)-нээс давсан байна. • Шуугиан Ажлын байрны шуугианы дундаж хэмжээ 74.1 дБА тодорхойлогдсон нь MNS6768:2019 стандартад заасан 8 цагийн дундаж өртөлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (85 дБА)-нд байна. • Гэрэлтүүлэг Ажлын байрны гэрэлтүүлэгт хэмжилтээр 17 ажлын байранд 43-428 люкс хэмжигдсэн нь MNS 6767:2019 стандартад заасан (500 люкс) эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрэхгүй байна. Мөн дараах хэмжилт хийсэн ажлын 15 байрны гэрэлтүүлэг 48-262 люкс байсан нь MNS 6767:2019 стандартад заасан (300 люкс) эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрэхгүй байна. Нэг ажлын байрны гэрэлтүүлгийн дундаж хэмжээ 547 люкс тодорхойлогдсон нь MNS 6767:2019 стандартад заасан (750 люкс) эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрэхгүй байна. Хоёр ажлын байранд 293 люкс, 713 люкс тус тус хэмжигдсэн нь MNS 6767:2019 стандартад заасан (1000 люкс) зөвшөөрөгдөх хэмжээнд хүрэхгүй, эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна. • Нүүрстөрөгчийн давхар исэл Ажлын байрны агаар дахь нүүрстөрөгчийн давхар ислийн	
--	--	--	--	--	--	--	--

						хэмжээг Extech CO багажаар хэмжив. Нүүрстөрөгчийн давхар ислийн концентраци MNS 4585:2016 стандартад заасан 8 цагийн дундаж өртөлтийн зөвшөөрөгдөх хэмжээ (1800мг/м^3)-ээс хэтрээгүй, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй түвшинд байна. Цулцанд нэвтэрдэг тоос Цулцанд нэвтэрдэг тоосонцорын агууламж MNS 4990:2015 стандартад заасан 8 цагийн дундаж зөвшөөрөгдөх дээд хэмжээ (3мг/м^3)-ээс хэтрээгүй байна.	
--	--	--	--	--	--	--	--

ГУРАВ. НОТОЛГООНД СУУРИЛСАН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ

3.1	Нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.		Нэвтрүүлж, хөгжүүлсэн технологийн нэр төрөл, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	2020 онд Монголд анх удаа өвдөгний үений мөгөөрсөн эдийн гэмтлийн үед дурангийн аргаар мөгөөрс шилжүүлэн суулгах мэс засал, тархины мэс заслын явцад гавлын ясыг буцаан нөхөж био буюу хайлдаг ялтсаар бэхлэх аргыг нэвтрүүлсэн.	3-аас доошгүй төрлийн оношилгоо эмчилгээний шинэ технологи нэвтрүүлсэн байна.	- Анх удаа 5G төхөөрөмж ашиглан Тайвань улстай холбогдон төрөлхийн шалтгаан тодорхойгүй нурууны мурийлт гэсэн оноштой 3 өвчтөнийг үзэж, санал бодлоо хуваалцан, оношилж, эмчлүүлэгдчийн цаашдын эмчилгээний асуудлыг шийдвэрлэсэн. Мөн 5G ухаалаг төхөөрөмж ашиглан дурангийн мэс заслыг Тайвань улсын эмч нартай холбогдон цахимаар хийсэн. - Дижитал суурин рентген аппарат багана нуруу болон доод мөчний дэлгэмэл зураг авах боломжтой ба ингэснээр өнцөг засах, өвдөгний үе солих мэс засал, нурууны муруйлт засах зэрэг хагалгааны үр дүнг хянах бүрэн боломжтой. “CORDER” брэндийн нүдний бичил мэс заслын микроскопыг Гэмтэл Согор Судлалын Үндэсний Төв нь 2016 оноос эхлэн гэмтлийн гаралтай нүдний нөхөн сэргээх мэс заслуудыг	100%
-----	--	--	---	--	---	---	------

						хийж эхэлсэн бөгөөд өнөөдөр бид нүдний бичил мэс засал хийх микро-скоптой болсноор нүдний алимны гэмтлийн үед тусламж үзүүлэх бүрэн боломжтой болсон. • Анх удаа хүзүүний нугалмын хугарал мултралыг арын хүрцээр дагз ястай бэхлэх мэс заслыг амжилттай нэвтрүүлсэн. • Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн зөвлөх эмч, Монгол Улсын Хүний Гавьяат эмч Б.Бүргэдээр ахлуулсан Гар сарвуу нөхөн сэргээх бичил мэс заслын тасгийн баг хамт олон Монголд анх удаа “ТОХОЙНЫ ҮЕ БҮТЭН СОЛИХ” мэс заслыг амжилттай хийж тус тус амжилттай нутагшуулсан. • ДЭМБайгууллагын санхүүжилтээр дурангийн мэс заслын Загвар сургалтын иж бүрэн төхөөрөмжтэй болсон. • Бүх шатлалын эмч нар, резидент эмч нар болон оюутнуудад дурангийн мэс заслын анхан болон дунд шатны дадлагажуулах сургалтыг үе шаттай хийх бүрэн боломжтой болсон. Эрүүл мэндийн салбарын эмнэлгүүд дотроос анхны мэс засал, сувилахуйн дуураймал эмнэлзүйн сургалтын орчинг санаачлан байгуулан, бүрэн ашиглалтанд оруулсан. • XXIII Гэмтэл согог судлалын ээлжит чуулганаар анх удаа шинээр нэвтрүүлсэн мэс заслын арга, инновацийн бүтээлийг шалгаруулсан.	
--	--	--	--	--	--	---	--

						• Шинээр суурилагдсан компьютерт томографийн аппаратыг сетунари ххк-ны инженерүүдтэй хамтарч угсарч суурилуулан хүлээн авч ашиглалтанд оруулав. • Гемодиализ эмчилгээ (бөөр орлуулах эмчилгээ) NIPRO-NCU 18 брэндийн аппаратаар 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдөр THCMЗТасагтай хамтран гемодиализын багаар хамтран эмчилгээ үйлчилгээ хийж гүйцэтгэсэн. Мөн ЭЭТасагт хүнд гэмтэлтэй өвчтөнд гемодиализын аппарат эмчилгээг 2 удаа хийсэн. Нийт 9 үйлчлүүлэгчдэд 42 удаагийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. • Олон мөчдийн хугаралтай өвчтөнд үүссэн уушигны артерийн тромбозмболи-ийн үед бүлэн хайлуулах эмчилгээг анх удаа гэмтлийн дараах 5 хоногтойд амжилттай хэрэгжүүлэн ажилласан.	
3.2	Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг хэвтүүлэн эмчлэх тасгуудад нэвтрүүлнэ.		Магадлан итгэмжлэлийн гэрчилгээ	ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэхэд шаардлагатай 8 журмыг боловсруулан, батлан ажилласан.	Хэвтүүлэн эмчлэх тасгуудад стандартыг нэвтрүүлсэн байна.	• Гэмтэл согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрий А/135 тоот тушаалаар Магадлан итгэмжлэлд бэлтгэх багийн бүрэлдэхүүнийг батлан тушаалын дагуу төлөвлөгөө гарган ажилласан. • Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/315 тоот тушаалаар магадлан итгэмжлэлийн гэрчилгээ авсан /Батламжийн дугаар 202/2021/.	100%

3.3	Эмчилгээний чанар, аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, хариу рефорт илгээж, тайлагнана.		Хяналт шалгалтын тоо, үр дүнгийн үзүүлэлт	Эмнэлзүйн удирдамж, стандартын дагуу хяналтын хуудас гарган сар бүр дотоод хяналт шалгалтыг хийж, үр дүнг тооцож, зөвлөж, сургалт зохион байгуулсан.	Жилд 10-с доошгүй удаа хяналт шалгалт хийж, үр дүн 25 хувиар сайжирсан байна.	- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын алба, халдварын сэргийлэлт хяналтын алба, сувилахуйн мэргэжлийн алба, хөдөлмөр аюулгүй байдлын мэргэжилтэнүүд хамтран болон удирдамжтайгаар 2021 онд нийт 11 удаагийн хяналт шалгалт хийж Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан дэд захирлаар баталгаажуулсан удирдамжтай хяналт шалгалт хийж, тасаг нэгжид тусламж үйлчилгээтэй холбоотой зөвлөмж хүргүүлэн ажилласан. Зөвлөмжийн дагуу хяналтыг 14-21 хоногийн дараа хийж хэвшсэн. - ГССҮТөвд 2021 онд “Ковид-19” вирусын шалтгаант нас баралт 20 бүртгэгдэж, ЭМС-2021 оны А/214-тоот тушаалын дагуу улаан бүр байгуулан хэрэгжүүлж ажилласан	100%
3.4	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.		Нэмэгдүүлсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо	2020 оны байдлаар эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийг 60 ширхэгээр нэмэгдүүлсэн.	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоог 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлсэн байна.	2021 онд эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж 29.6 хувиар нэмэгдсэн байна. Үүнд ЭМС-ын 2021.01.27-ний А/31, ЭМС-ын 2021.03.15-ний А/126, ЭМС-ын 2021.05.20-ний А/327, ЭМС-ын 2021.03.17-ний А/132, ЭМС-ын 2021.10.22-ний А/636, ЭМС-ын 2021.12.09-ний А/766 тоот тушаалуудыг тус тус үндэслэн 4,3 тэрбум төгрөгийн 16 нэр төрлийн 283 ширхэг тоног	100%

						төхөөрөмжийг Коронавируст халдвар түүнээс урьчилан сэргийлэх бэлэн байдлыг хангаж ажиллахад шаардагдах амьсгалын аппарат 12 ширхэг, уушиг хянах аппарат 3 ширхэг, сөрөг даралттай өвчтөн зөөвөрлөх ор 1 ширхэг, гемодиализын аппарат 1 ширхэг, өвчтөний хяналтын монитор 35 ширхэг, отсос 35 ширхэг, тарианы автомат шахуурга 35 ширхэг, дижитал зөөврийн рентген аппарат 1 ширхэг зэрэг тоног төхөөрөмж, Мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн хүрээнд нийлүүлэгдсэн өдөр тутмын үйл ажиллагаа, эмчилгээ үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангахад хэрэглэгддэг автомат тарианы шахуурга, автомат арьс авагч, өвчтөний хяналтын монитор, утасгүй ЭХО аппарат, бичил мэс заслын микроскоп, бичил мэс заслын багаж, дрилл, мэс заслын ор, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат нөүтбүүк, компьютер зэрэг 162,2 сая төгрөгийн үнэ бүхий 18 нэр төрлийн 30 ширхэг эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн хүлээн авч бүртгэлд тусган ажилласан.	
--	--	--	--	--	--	---	--

3.5	Орон нутаг болон дүүргийн эмч нарын чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор зонхилон тохиолдож байгаа осол гэмтлийн үеийн тусламж үйлчилгээ, эмчилгээ оношилгооны сургалтуудыг зохион байгуулна	20 сая	Сургалтад хамрагдсан тоо хүний	2020 онд цахим сургалтыг 4 удаа зохион байгуулсан	Эмч эмнэлгийн ажилчдын ур чадвар сайжирч, дүүрэг орон нутагт үзүүлсэн гэмтлийн тусламж үйлчилгээний тоо нэмэгдсэн байна.	• 2021 оны хагас жилийн байдлаар Орон нутгийн болон дүүргүүд, гэмтэл согогийн нийт эмч мэргэжилтнүүдийн осол гэмтлийн үед үзүүлэх хариу арга хэмжээг чадавхижуулах нийт 7 удаа 14 сэдвээр цахим сургалтыг 210 эмч мэргэжилтнүүдэд зохион байгуулсан. • Зүүн бүсийн аймгуудад (Хэнтий, Дорнод, Сүхбаатар) мөн Осол гэмтлийн тохиолдол ихтэй Говь-Алтай аймагт ДЭМБ-ын санхүүжилтээр Осол гэмтлийн үед үзүүлэх яаралтай тусламжийн 3 өдрийн сургалтыг 360 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, цагдаа, онцгой байдлын албан хаагч, нийгмийн ажилтануудад 2021 оны 08 дугаар сард зохион байгуулсан. • 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 14:00 цагт “Орон нутагт осол гэмтлийн үед тусламж үйлчилгээ үзүүлэхэд тулгамдаж буй асуудлуудад шийдэл хэлэлцэх нь” цахим хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт нийт 56 эмч, эмнэлгийн болон аймгийн ЭМГазрын удирдлагууд оролцсон. • Мөн ТНСМЗТ болон ГСНСБМЗТасгаас орон нутгийн эмч мэргэжилтнүүдэд зориулан “гэмтлийн дараах Зонхилон тохиолдол” сэдэвт 2	95%
-----	---	--------	--------------------------------	---	--	--	-----

						удаагийн цахим сургалт зохиосон.	
